



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/123

Мандалговь

Гахайн мялзан өвчин гарсантай  
холбогдуулан хорио цээрийн дэглэм  
тогтооход хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а" Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1, 2.4 дахь заалт, Засаг даргын зөвлөлийн хурлын 2019 оны 3 дугаар сарын 20-ний өдрийн 05 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Мал амьтны гоц халдварт Гахайн Африк мялзан өвчин гарсантай холбогдуулан хорио цээрийн дэглэм тогтоож хэрэгжилтийг хангах ажиллахад гарсан зардлыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Хорио цээрийн дэглэмд зарцуулсан 2501140 (Хоёр сая таван зуун нэгэн мянга нэг зуун дөчин) төгрөгийг Засаг даргын нууц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт тус тус зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190339

03 Аймгийн Засаг даргын 2019 оны  
... дугаар сарын ...-ны өдрийн ... тоот  
захирамжийн хавсралт



САЙНЦАГААН СУМЫН МАЛ, АМЬТАНЫ ГОЦ ХАЛДВАРТ ГАХАЙН  
МЯЛЗАН ӨВЧНИЙ ХОРИО ЦЭЭРИЙН ҮЕИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын төрөл	
1	Шуудан холбоо	100,000
2	Бараа материал	185,040
3	Хүнсний бүтээгдэхүүн	30,000
4	Шатахуун /СЗДТГ, Цагдаа/	1,067,600
5	Хоол /өдөрт 2 удаа/	731,500
6	Мод, нүүрс	247,000
7	Вагончикын түрээс	140,000
	Нийт зардлын дүн	2,501,140